

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Ханх сумын ТТЗ-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2025/016/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:  
[erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:  
[tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88012671 Цахим хаяг:  
[ichnhorlooga@audit.gov.mn](mailto:ichnhorlooga@audit.gov.mn)

Аудитор: Л.Мөнх-Оргил

Утас: 99039344 Цахим хаяг: [munkh-  
orgill@audit.gov.mn](mailto:munkh-<br/>orgill@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ХАНХ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Б.БЯМБАБАЯР ТАНАА

## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsngul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 1/334  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Ханх сумын ТТЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд ТТЗ-ийн хяналтад байгаа байгууллагуудын үндсэн хөрөнгө данс 596.1 сая төгрөгийн үнэ төлбөргүйгээр хүлээн авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Ханх сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 5.4 сая төгрөгийн 1 алдааг залруулж, төсөвт төвлөрүүлэх 5 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 6.2 сая төгрөгөөр тасалсан, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 18 иргэнтэй холбоотой 53.4 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулаагүй зөрчил илэрсэн.

#### Бусад асуудлын хэсэг

Ханх сумын Засаг дарга нь 2024 онд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт 74.1 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6725022200

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

		/Мянган төгрөгөөр/		
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		503,588.70	718,441.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	270,760.30	470,483.00
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	159,783.60	147,372.60
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	73,044.80	100,586.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,700,647.80	3,067,024.60
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	58,000.00	56,000.00
37300	Урт хугацаат зээл		58,000.00	56,000.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,642,647.80	3,011,024.60
39200	Биет хөрөнгө		2,580,701.80	2,944,178.60
39300	Биет бус хөрөнгө	13	61,946.00	66,846.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>3,204,236.50</b>	<b>3,785,466.40</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		22.6	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	22.6	0
41300	Өглөг	17а, 17б	22.6	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,204,213.90	3,785,466.40
51	Засгийн газрын хувь оролцоо		3,204,213.90	3,785,466.40
51100	Засгийн газрын оруулсан капитал		759,200.90	759,200.90
51200	Хуримтлагдсан үр дүн		2,079,240.90	2,660,493.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		365,772.10	365,772.10
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>3,204,236.50</b>	<b>3,785,466.40</b>

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,527,424.8	2,284,077.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО		340,687.0	620,600.50
110	Орлогын албан татвар		208,671.7	482,795.90
1100	Хувь хүний орлогын албан татвар		228,881.1	482,795.90
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-20,209.4	0
113	Хөрөнгийн албан татвар		16,786.7	26,738.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж		115,228.6	111,066.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,272,228.9	551,240.10
120	Нийтлэг татварын бус орлого		1,272,228.9	551,240.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		914,508.8	1,112,236.50
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,087,982.6	1,662,810.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,087,982.6	1,635,860.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,046,516.9	1,584,718.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		470,257.4	782,120.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		58,529.6	95,759.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		32,784.0	203,759.30
2104	Хангамж, бараа материалын зардал		67,535.4	124,845.30
2105	Нормативт зардал		0	1,106.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		11,314.60	45,017.00
2107	Томилолт, зочны зардал		11,171.40	12,158.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		216,919.70	54,964.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		178,004.80	264,987.60

Хөвсгөл аймгийн Ханх сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,003,753.70	51,141.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0	26,950.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,593,383.60	621,266.30
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		153,941.40	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		1,439,442.20	621,266.30

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Мянган төгрөгөөр/

I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		1,299,529.40	1754822.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО		340,687.00	620,600.50
110	Орлогын албан татвар		208,671.70	482,795.90
1100	Хувь хүний орлогын албан татвар		228,881.10	482,795.90
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-20,209.40	0
113	Хөрөнгийн албан татвар		16,786.70	26,738.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж		115,228.60	111,066.50
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		6,115.80	8,877.80
1181	Газрын төлбөр		58,903.50	34,550.90
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		50,209.20	67,637.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		35,433.60	39,232.90
120	Нийтлэг татварын бус орлого		35,433.60	39,232.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		923,408.80	1,094,989.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,074,087.20	1,369,633.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,074,087.20	1,369,633.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		869,780.10	1,318,491.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		469,610.70	781,588.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		59,021.70	96,314.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		24,927.90	199,617.60
2104	Хангамж, бараа материалын зардал		62,615.20	70,952.50
2105	Нормативт зардал		0	1,106.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		11,314.60	51,110.40
2107	Томилолт, зочны зардал		11,129.40	12,158.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		218,019.70	55,983.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		13,140.90	49,659.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		204,307.10	51,141.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		225,442.20	385,188.90
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		23,557.80	185,466.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		23,557.80	185,466.20
2200	Дотоод эх үүсвэрээр		23,557.80	185,466.20
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-23,557.80	-185,466.20
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-36,000.00	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		36,000.00	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		165,884.40	199,722.70
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		104,875.90	270,760.30

Хөвсгөл аймгийн Ханх сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		270,760.30	470,483.00
----	---	--	------------	------------

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,755,313.90	0	1,755,313.90
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	13,502.10	0	13,502.10
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,768,816.00	0	1,768,816.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-4,044.30	0	-4,044.30
9	Тайлант үеийн үр дүн	1,439,442.20	0	1,439,442.20
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,204,213.90	0	3,204,213.90
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,204,213.90	0	3,204,213.90
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-40,013.80	0	-40,013.80
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,164,200.00	0	3,164,200.00
19	Тайлант үеийн үр дүн	621,266.30	0	621,266.30
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,785,466.40	0	3,785,466.40

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,816,175.2</b>	<b>1,479,724.9</b>	<b>336,450.3</b>	<b>81.5</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,335,943.2</b>	<b>1,322,686.6</b>	<b>13,256.6</b>	<b>99.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,319,063.7</b>	<b>1,305,904.8</b>	<b>13,158.9</b>	<b>99.0</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>787,502.1</b>	<b>781,588.4</b>	<b>5,913.7</b>	<b>99.2</b>
210101	Үндсэн цалин	430,572.6	424,978.7	5,593.9	98.7
210102	Нэмэгдэл	342,529.5	339,870.1	2,659.4	99.2
210104	Урамшуулал	14,400.0	16,739.6	-2,339.6	116.2
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>96,314.9</b>	<b>96,314.9</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	66,373.9	66,373.9	0.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,485.2	7,485.2	0.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,742.7	3,742.7	0.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,742.7	3,742.7	0.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	14,970.4	14,970.4	0.0	100.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>202,070.0</b>	<b>199,617.6</b>	<b>2,452.4</b>	<b>98.8</b>
210301	Гэрэл, цахилгаан	30,650.0	28,243.8	2,406.2	92.1
210302	Түлш, халаалт	154,870.0	154,870.0	0.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	16,550.0	16,503.8	46.2	99.7
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>69,257.6</b>	<b>69,257.5</b>	<b>0.1</b>	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	23,357.6	23,357.5	0.1	100.0
210402	Тээвэр, шатахуун	32,100.0	32,100.0	0.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,900.0	3,900.0	0.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,900.0	9,900.0	0.0	100.0

Хөвсгөл аймгийн Ханх сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,106.0</b>	<b>1,106.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,106.0	1,106.0	0.0	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>71,538.4</b>	<b>71,538.4</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,600.0	24,600.0	0.0	100.0
210602	Тавилга	828.0	828.0	0.0	100.0
210604	Урсгал засвар	46,110.4	46,110.4	0.0	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>11,534.4</b>	<b>11,521.0</b>	<b>13.4</b>	<b>99.9</b>
210702	Дотоод албан томилолт	11,534.4	11,521.0	13.4	99.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>60,077.4</b>	<b>55,301.2</b>	<b>4,776.2</b>	<b>92.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,621.7	50,911.5	4,710.2	91.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,584.0	1,584.0	0.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	165.0	112.0	53.0	67.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120.0	119.1	0.9	99.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88.2	88.2	0.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,050.0	2,038.0	12.0	99.4
210807	Газрын төлбөр	448.5	448.4	0.1	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>19,662.9</b>	<b>19,659.8</b>	<b>3.2</b>	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,244.1	16,241.0	3.1	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,418.8	3,418.8	0.0	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,879.5</b>	<b>16,781.8</b>	<b>97.7</b>	<b>99.4</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>16,879.5</b>	<b>16,781.8</b>	<b>97.7</b>	<b>99.4</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,753.0	14,655.3	97.7	99.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,126.5	2,126.5	0.0	100.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>430,232.0</b>	<b>157,038.3</b>	<b>273,193.8</b>	<b>36.5</b>
223001	Бусад хөрөнгө	430,232.0	157,038.3	273,193.8	36.5
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>50,000.0</b>	<b>0.0</b>	<b>50,000.0</b>	<b>0.0</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	50,000.0	0.0	50,000.0	0.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,816,175.2</b>	<b>1,595,274.7</b>	<b>220,900.5</b>	<b>87.8</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>227,029.3</b>	<b>227,029.3</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	227,029.3	227,029.3	0.0	100.0
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,260,482.4</b>	<b>1,331,176.6</b>	<b>-70,694.2</b>	<b>105.6</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,260,482.4	1,331,176.6	-70,694.2	105.6
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>328,663.5</b>	<b>37,068.8</b>	<b>291,594.7</b>	<b>11.3</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000.0	35,974.7	14,025.3	71.9
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	1,094.1	-1,094.1	0.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	278,663.5	0.0	278,663.5	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	172,668.7	-	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	288,218.6	-	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>53.0</b>	<b>47.0</b>	<b>6.0</b>	<b>88.7</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.0</b>	<b>1.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	0.0	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>26.0</b>	<b>23.0</b>	<b>3.0</b>	<b>88.5</b>
620001	Удирдах ажилтан	4.0	3.0	1.0	75.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16.0	14.0	2.0	87.5

Хөвсгөл аймгийн Ханх сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

620003	Үйлчлэх ажилтан	6.0	6.0	0.0	100.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>26.0</b>	<b>23.0</b>	<b>3.0</b>	<b>88.5</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.0	8.0	2.0	80.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.0	9.0	0.0	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.0	6.0	1.0	85.7

**2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>75,447.7</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>75,447.7</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>41,014.9</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,695.0</b>
210402	Тээвэр, шатахуун	1,695.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,000.0</b>
210604	Урсгал засвар	5,000.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>637.9</b>
210702	Дотоод албан томиллолт	637.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,682.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,682.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>30,000.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,432.9</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>34,360.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,360.0
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>72.9</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	72.9
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>75,447.7</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>75,447.7</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	69,765.7
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,682.0

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 сан, 1 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

**Харьяа байгууллагуудтай холбоотой зөрчил**

Ханх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 28.5 сая төгрөгийн алдаа илрүүлэн аудитын явцад бүрэн залруулж, Төсвийн зориулалт бус зарцуулалттай холбоотой 5.9 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 6.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгч, 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

**Төсвийн төвлөрүүлэн захирагчтай холбоотой зөрчил**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 65 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүү байдлын тайланд 5.4 сая төгрөгийн авлагыг нэгтгээгүй 1 алдааг залруулж, 59.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмжийг өгсөн байна.

Ханх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс хэтрээгүй тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн болно.

## 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар

Аудитын илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сан нь 18 зээлдэгчийн 53.4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага байна. Үүнээс: 8 иргэний 29.2 сая төгрөгийн зээл шүүхийн шатанд, 10 иргэний 23.8 сая төгрөгийн зээлийн авлагад засаг даргын мэдэгдэл хүргүүлсэн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийг бүрэн барагдуулаагүй нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах

### 2. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

- Орон нутгийн төсвийн орлогоос Үл хөдлөх хөрөнгийн татвар 2.2 сая төгрөгөөр, газрын төлбөр 0.4 сая төгрөг, торгуулийн орлого 1.1 сая төгрөг нийт 3 нэр төрлийн 3.7 сая төгрөгийн орлого тасарсан байна.
- Улсын төсөвт төвлөрүүлэх орлогоос дотоод бараа үйлчилгээний НӨАТ-ыг 2.3 сая төгрөгөөр, агаарын бохирдлыг 0.2 сая төгрөг нийт 2 нэр төрлийн орлого 2.5 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт, Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын орлогыг бодитой төлөвлөж, нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах зөвлөмж өгөх.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5."Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 1. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		
							Тоо	Дүн	Тоо	Дүн	
ТТЗ											
Соёлын төвийн 5.4 сая төгрөгийн авлагыг нэгтгээгүй байна	1	5.4	1	5.4			1	5.4			
ЗДТГ											
Үндсэн хөрөнгө данс бүртгэлд бүртгээгүй	2	8.0	1	5.0	1	3.0	2	8.0			
Бараа материал данс бүртгэлд бүртгээгүй	1	3.3			1	3.3	1	3.3			

Хөвсгөл аймгийн Ханх сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Авлага тайланд тусгаагүй	2	17.2	2	17.2			2	17.2		
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>28.5</b>	<b>3</b>	<b>22.2</b>	<b>2</b>	<b>6.3</b>	<b>5</b>	<b>28.5</b>		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ												
Орлого бүрдүүлэлттэй холбоотой	1	6.2					1	6.2				
Хугацаа хэтэрсэн зээлийн авлага	1	53.4					1	53.4				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>59.6</b>					<b>2</b>	<b>59.6</b>				
<b>Харьяа байгууллагуудын зөрчил</b>												
Төсвийн зориулалт бус зарцуулалт /ЗДТГ/	2	10.6	1	4.5	1	6.1						
<b>Дүн</b>												
Төсвийн зориулалт бус зарцуулалт /ИТХ/	1	1.4	1	1.4								
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>12.0</b>	<b>1</b>	<b>5.9</b>	<b>1</b>	<b>6.1</b>						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /ЗДТГ/</b>								
Ахмадын сан байгуулаагүй	1	0					1	0
ХАА-ны гэрээнд үнэ тоо хэмжээг тусгаагүй, босго үнэ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй	1	0			1	0		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>0</b>			<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БАТАЛГААЖУУЛСАН:  
АУДИТОР



Л.МӨНХ-ОРГИЛ ОГНОО: